



**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилгын үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайлан**

2018 он

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг
ОУЗСТ-ийн Ажлын алба

АГУУЛГА

Нэг. Үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ

Товч хураангуй

Монгол Улс ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангасан орноор хүлээн зөвшөөрөгдсөн нь 2018 оны гол үйл явдал болсон байна.

Монгол Улсын Ерөнхий сайд, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн дарга У.Хүрэлсүхээс Монгол Улсад ОУИТБС-ыг цаашид тогтвортой хэрэгжүүлнэ гэдгээ нотолсон албан захиаг ОУИТБС-ын дарга ноён Ф.Райнфелдэт хүргүүлсэн байна.

Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Сумьяабазарын албан захиаг ноён Ф.Райнфелдэт хүргүүлж, Монгол Улсад дэмжлэг үзүүлж, байгаад гүнээ талархалаа илэрхийлсэн байна. Баталгаажуулалтын дүнгийн дагуу авах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хүргүүлсэн байна.

ОУИТБС-ын ОУНБДНГ-ын гүйцэтгэх тэргүүн ноён Й.Моберг манай улсад айлчилж, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, ОУИТБС-ын тухай танилцуулсан байна. Мөн Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Сумьяабазарт бараалхаж, Монгол Улс ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаад дүгнэлтээ өгч, цаашдын хамтын ажиллагааны чиглэлүүдийн талаар хэлэлцсэн байна. Мөн орлогч захирал ноён Эдди Рич Монгол Улсад айлчилж, ОУИТБС-ын хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон байна.

“Нээлттэй засаг түншлэл” олон улсын Засгийн газар хоорондын байгууллага, ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын урилгаар ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайдын ажлын албаны дарга, Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энх-Амгалан нар Гүрж улсад айлчилж, Нээлттэй засгийн түншлэлийн дээд хэмжээний уулзалтад оролцохын хамт ОУИТБС-ын Төв Ази, Өвөр Кавказын бүсийн хуралд оролцож, ОУИТБС-ын хэрэгжилтийн байдлаа танилцуулж, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох тухай хэлэлцүүлэгт оролцож, Гүрж Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх боломжтой ажлын талаар санал солилцсон байна.

Ил тод байдлын гол бүтээгдэхүүн болох Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны нэгтгэл тайланг хугацаандаа гаргаж, олон нийтийн хүртээл болгосон байна.

Ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 1489 компани, Засгийн газар 2091 компаниас хүлээн авсан орлогоо ил тод цахимаар тайлагнаж, 2017 оны нэгтгэл тайланг Монгол Улсын тэргүүлэх 230 компаниар гаргасан байна. Олборлох үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд усны хэрэглээ, хог хаягдлын устгалын мэдээ зэрэг шинэ мэдээллийг энэ тайлангаар гаргаж байна.

Орон нутагт ОУИТБС-ыг сурталчлах, харилцан ойлголцлыг бүрдүүлэх зорилгоор ЕСБХБ-ын санхүүжилтээр Адам Смит хүрээлэн, Монголын Интерконсалтинг компанитай хамтран Ерөө, Заамар, Гурвантэс, Бор-Өндөр, Дэлгэрэх сумдад туршилтын төслийг хэрэгжүүлж, дуусган үлдсэн хугацаанд өөрсдийн хүч бололцоонд тулгуурлан хэрэгжүүлж байна.

Олборлох салбарын аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч эздийг ил тод болгох “Замын Зураг” төлөвлөгөөнөөс 2018 онд төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэхийн хамт ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газартай хамтран ажиллаж, төрийн байгууллагууды дугуй ширээ, УИХ, ЗГ-ын түвшиний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулан, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн боловсруулан ЗГХЭГ-д өргөн барьсныг УИХ-ын гишүүнд хүргүүлсэн байна.

Олборлох салбарт байгуулагдсан гэрээнүүдийн ил тод байдлыг хангахын тулд Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр гэрээний цахим санг үүсгэснийг баяжуулах, мэдээллийг шинэчлэх арга хэмжээг УУХҮЯ-тай хамтран авсаны үр дүнд 280 гаруй гэрээний мэдээллийг ил тод болгосон байна.

Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлээд 10 гаруй жил болсон үр дүнг дүгнэж, мэдээлэл сурталчилгааны томоохон арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд үүнд Монгол Улсад ОУИТБС-ыг эхлүүлж байхад оролцсон анхны гишүүд, одоогийн гишүүд хамтран өөр өөрийн зүгээс дүгнэлт, үнэлгээгээ өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулсан байна.

2018 онд томоохон өөрчлөлт орсон нь Ерөнхий сайдын ажлын ачааллыг нимгэлэх зорилгоор Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн даргын үүргийг Монгол Улсын Ерөнхий сайд хэрэгжүүлж байсныг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад, Ажлыг хэсгийн ахлагчийн үүргийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад шилжүүлж, Засгийн газраас 9 дүгээр сард 289 тоот холбогдох тогтоолыг гаргасан байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр дүн, үр нөлөө, ахиц дэвшил

1. Тайлан гаргаж байгаа нь компанийн хариуцлагатай байдал нэмэгдэж буйн бодит жишээ юм.

2017 онд 1489 компани тайлан гаргасан нь 2006 оныхоос 23 дахин өсч, хариуцлагатай компаниудын тоо нэмэгдсэн байна.

2. Засгийн газраас тайлангаа саадгүй гаргаж байгаа нь хариуцлагатай байдал, манлайлал сайжирч байгаагийн илрэл юм.

2017 онд 2091 компаниас хүлээн авсан орлогоор Засгийн газар тайлан гаргасан нь 2006 оныхоос 15 дахин өссөн тоон үзүүлэлт юм. Засгийн газар нь сүүлийн 5 жилд дараалан тусгай зөвшөөрөл эзэмшигч бараг бүх компаниар орлогоо тайлагнаж байгаа нь хариуцлагатай байдал нэмэгдсэний илрэл гэж үзэх үндэстэй байна.

3. Бодитой мэдээллийн хүртээмж эрс нэмэгдэж, ОУИТБС-ын тайлагнал цахимжав.

2007-2013 он хүртэл Компани, Засгийн газар ОУИТБС-ын тайлангаа цаасаар гаргаж байсан бол 2014 оноос цахимаар гаргаж, Засгийн газар, Компанийн үнэт цаг, цаас, зардлыг хэмнэсэн “Эко” тайлан руу дөхөж очсон байна. Тайлагналыг цахимжуулж, хэрэглэгчид ээлтэй болгосон учир тайлагнах компани, тайланд хамрагдах компанийн тоо өссөн байна.

4. Засгийн газар, Компани, Иргэний нийгэм мэдлэг, чадавх нэмэгдэж байна.

Оролцогч 3 талын чадавх нэмэгдэж байгаа нь жил бүр тайлан гаргаж, хэлэлцүүлэг зохион байгуулж, тайлангаа олон улсын стандартын жишиг хугацаанаас 1 жилийн өмнө гаргаж, 2011 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлангаас хэвшээд байна.

5. Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд өсөв.

2011, 2016 онд ОУИТБС-ын даргын нэрэмжит Болор цомоор шагнуулав. Эдгээр шагналууд нь жил бүр тайлангийн чанарыг сайжруулдаг, хүртээмжийг нэмэгдүүлснийг үнэлсэн явдал байлаа. 2018 онд Монгол Улс ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангасан орноор хүлээн зөвшөөрөгдөв.

6. Монгол Улсын байгалийн баялгийн засаглалын индекс 64 болж нэмэгдэв.¹

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд Засгийн газар, компани, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бодитойгоор идэвхжин, нэмэгдэж, итгэлцлийг уур амьсгал сайжирснаар засаглалын энэхүү индекс өсөх шалтгаан болов.

7. Төв, орон нутгийн төрийн байгууллагуудад олгосон, өмнө нь ил болдоггүй байсан хандив дэмжлэгийг 2007 оноос хойш ил тод болгож байна.

УИХ, Засгийн газраас замбараагүй хандив дэмжлэгийг асуудлыг холбогдох хуулиудаар зохицуулах арга хэмжээ авч байна. Тухайлбал, 2010 оны Сангийн сайдын 45 дугаар тушаал, 2011 онд батлагдсан “Төсвийн тухай” хуулийн 25 дугаар зүйл, 2012 онд батлагдсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 17.1, 17.4-заалтуудаар хандив дэмжлэгтэй холбогдсон асуудлыг зохицуулж байгаа нь томоохон ахиц дэвшил болж байна.

¹ Өмнөх оноо 2013 онд 51 байсан.

8. Байгаль орчны нөхөн сэргээлтийн дүн мэдээ, холбогдох барьцааг ил тод болгож байна. 2017 оны нэгтгэл тайлангаас эхлэн хэрэглэсэн ус, хог хаягдлынхаа тухай компаниуд тайлагнаж эхлэсэн байна.²

Байгаль орчны нөхөн сэргээлт, хэрэглэсэн ус, хог хаягдлын мэдээг ил тод болгож байгаа нь ОУИТБС-ын стандартаас давсан үйл ажиллагаа үйл ажиллагаа болж байна.

9. ОУИТБС-ын салбар болох Дэд зөвлөлийг хөдөө орон нутаг, нийслэлд байгуулж, компани, төв орон нутгийн хоорондын харилцаа холбоог сайжруулах боломжтой болов.

Орон нутгийн хамтын ажиллагааны олон бодит жишээг дурдаж болно. 21 аймаг, нийслэл, 1 дүүрэг, 12 суманд ОУИТБС-ын дэд зөвлөл байгуулан ажиллаж байна.

10. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлснээр олон нийтийн хэлэлцүүлгийн индэр болжээ.

Хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр ОУИТБС-ын ач холбогдол, хэрэгжилтийг бүрэн, ямар ч хязгаарлалтгүйгээр, чөлөөтэй хэлэлцэж байна.

11. ОУИТБС-ын тайлангийн мэдээллийг ашиглан ажил хэрэгч маргааныг шийдвэрлэх тохиолдол нэг биш удаа гарч байна.

“Бороо гоулд” компаниас татвар төлсөн төлөөгүй маргааны үеэр ОУИТБС-ын тайлагнасан дүнг танилцуулж, маргааныг шийдвэрлэж байсан тохиолдол гарч байсан. “Энержи ресурс” ХХК ОУИТБС-ын мэдээллийг өөрийн компанийн үйл ажиллагааны тухай ойлголтыг сайжруулахад ашиглаж байна.³

Хэдийгээр Монгол Улс ОУИТБС-ыг 10 гаруй жил хэрэгжүүлж, дэлхийн эхний эгнээнд тэргүүлэх орны нэгээр үнэлэгдэж байгаа ч, эдгээр амжилтыг тогтвортой авч явах, төр, компанийн өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй хэсэг болгоход хамгийн эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хуульчилах хэрэгтэй байна.

Хэрэгжилтийн үнэлгээг иргэд, олон нийтийн зүгээс хийлгэх, санал асуулга авах зэрэг шинэлэг арга хэмжээ авах хэрэгтэй байна.

² Хэрэглэсэн усны мэдээллээ 113, хог хаягдлын мэдээллээ 100 компани 2017 оны тайландаа оруулсан. 2017 оны нэгтгэл тайлангийн 31, 32-р хавсралтууд

³ Монголиан Майнинг Журнал-2018 оны 11 дүгээр сарын дугаар.

Үндсэн гол үйл ажиллагаанууд-2018 он

Компаниуд, Засгийн газрын байгууллагуудын 2017 оны тайлагнал

Компани, Засгийн газрын байгууллагуудын 2017 оны тайлан гаргах ажлыг холбогдох төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Үүний үр дүнд ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 1489 компани тайлангаа (хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 798, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 680, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй 11 компани), Засгийн газрын харъяаны 8 яам, агентлаг, 21 аймаг, 9 дүүргийн Засаг даргын тамгын газрууд нийт 2086 компаниас орлого хүлээн авсан тухай тайлангаа тус тус цахимаар гаргасан байна. Энэ жилийн компанийн тайлагнал өмнөх оноос 64 хувиар өссөн байна.

Орлого хүлээн авсан байгууллага, дүүрэг, аймгуудыг танилцуулахад Ашигт малтмал, газрын тосны газар 1847, Татварын ерөнхий газар 746, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 947, Гаалийн ерөнхий газар 285, Баянгол дүүрэг 127, Сүхбаатар дүүрэг 124, Дорноговь аймаг 110, Төв аймаг 81, Дундговь аймаг 58, Говь-Алтай аймаг 55 компаниас хүлээн авсан орлогоороо тайлан гаргасан байна. Бусад байгууллага, дүүрэг, аймгуудыг хавсралтаар харуулав.

2016-2017 оны Баталгаажуулалтын дүн

ОУИТБС-ын Удирдах хорооноос 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсын 2016 оны ОУИТБС-ын баталгаажуулалтын дүнг баталж, засч сайжруулах 7 зөвлөмжүүдийн биелэлтийг 2018 оны 1 дүгээр сард хянан хэлэлцэж, 2 дугаар сард Монгол Улсыг ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангасан орноор хүлээн зөвшөөрсөн нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй 50 гаруй орнуудаас 2-дох орон болсон нь томоохон амжилт гэж үзэж байна.

Монгол Улсын 2017 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлан буюу 12 дугаар тайлангийн удирдамжийг боловсруулсан байдал

2018 оны эхээр Ажлын хэсгийн гишүүдэд 12 дугаар тайланг гаргах хараат бус хянан нэгтгэгчийг сонгон шалгаруулах болон ажиллах удирдамжийг цахимаар илгээж, санал авсаны үндсэн дээр батлуулж хэвлэн нийтлүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Үнэлгээний хороог Ажлын албан дээр байгуулан, хороог АМГТГ-ын ахлах мэргэжилтэн Ц.Цэгцээр ахлуулан, ЗГХЭГ-ын мэргэжилтэн М.Цэрэнжүрмэд, Монголын УУҮА-ийн ерөнхийлөгч Н.Алгаа, Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан П.Болормаа, Байгаль орчины иргэний зөвлөлийн удирдах хорооны гишүүн Б.Батболд, Захиргааны шинэ санаачилга ТББ-ын ажилтан Б.Цэрэнпүрэв, Ажлын албаны мэдээллийн технологийн зөвлөх Г.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргын тушаалын дагуу байгуулж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Мөн ОУИТБС-ын ОУНБДнГ-ын хариуцсан мэргэжилтнүүдээс энэ удирдамжийн төсөлд санал авч, холбогдох саналыг тусган, сонгон шалгаруулалтыг 1 дүгээр сард зарлан, эхлүүлсэн болно.

Сонгон шалгаруулалт, гэрээ байгуулсан нь

2017 оны ОУИТБС-ын тайлан гаргах Аудиторын түншлэлийн сонгон шалгаруулалтад КейПиЭмЖи аудит-Монгол, КейПиЭмЖи аудит-Франц компаниудын консорциум, Улаанбаатар аудит корпорац, Монгол, Харт Нойрс, Их Британ компаниудын консорциум, Од бүртгэл аудит Монгол, Моорс Стефенс, Тринидад Тобаго компаниудын консорциум, БДО, Монгол, Скай Тийм Норвег компаниудын консорциум оролцсон байна.

Явцын дунд КейПиЭмЖи аудит-Монгол, КейПиЭмЖи аудит-Франц компаниудын консорциумаас гомдол гарсныг холбогдох журмын дагуу Сангийн яаман дээр хянагдан шийдэгдсэн бөгөөд гэрээ байгуулах ажлыг удааширах шалтгаан болсон байна

Сонгон шалгаруулалтаар Монгол, Их Британ улсуудын Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс компаниудын консорциум шалгарч, гэрээг 6 дугаар сарын 19-нд байгуулж, гэрээт ажил буюу эхлэлийн семинарыг 7 дугаар сарын 6-нд зохион байгуулж, эхлэлийн тайланг 8 дугаар сарын 30-нд зохион байгуулсан байна.

Ажлын хэсэгт 11 дүгээр сард тайлангийн төслөө танилцуулан, холбогдох дүгнэлтийн дагуу Үндэсний зөвлөлд тайлангаа эцэслэн 12 дугаар сарын 19-ний өдөр танилцуулсныг баталсан байна.

Нэгтгэлийн үйл ажиллагаа

Монгол, Их Британ улсуудын Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс компаниудын консорциум нь 2017 оны тайланг ОУИТБС-ын стандартын дагуу боловсруулж, тэргүүлэх 230 компанийн тайланг Засгийн газрын тайлантай тулган баталгаажуулж, холбогдох дүгнэлтүүдийг хийж, зөвлөмж гаргасан байна. Нэгтгэлийн үйл ажиллагаа 7 дугаар сард эхлэж, 11 дүгээр сар хүртэл үргэлжилсэн нь наадам, амралтын хугацаатай давхцах, эдгээрээс улбаалан, байгууллага компаниуд хариу өгөх ажил удаашралтай байсантай холбоотой ажээ.

12 дугаар тайлангийн төслийг хэлэлцсэн байдал

Монгол, Их Британ улсуудын Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс компаниудын консорциумаас тайлангийн төслийг Ажлын хэсэгт 11 дүгээр сард танилцуулж, хэлэлцүүлсэн бөгөөд зохих нэмэж анхаарах зүйлсийг зөвлөмж болгосны үндсэн дээр Ажлын хэсгийн зүгээс дэмжлэг өгсөн байна. Үндэсний Зөвлөлд танилцуулж, батлуулахыг эцсийн хувилбарыг засч сайжруулах зөвлөмжийг өгсөний дараа засч сайжруулан танилцуулж байна.

Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын тухай

Олборлох салбарын аж ахуйн нэгжийн ашиг хүртэгч эздийг ил тод болгох “Замын зураг” хөтөлбөрийн дагуу төрийн байгууллагуудын төлөөллийн дугуй ширээг 2, УИХ, ЗГ-ын удирдлагын түвшиний зөвлөлдөх уулзалтыг 5, компаниудын зөвлөлдөх уулзалтыг 12 дугаар саруудад ОУИТБС-ын ОУ-ын НБДНГ тай хамтран ЕСБХБ-ы санхүүжилтээр зохион байгуулсан.

5-р сарын уулзалтаас гарсан зөвлөмжийн дагуу тухайн үед хэлэлцэгдэж байсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлтийг саналыг бэлтгэн оруулсан боловч хоцорсон байна.

Өөрийн төслийн санхүүгийн боломжид тулгуурлан энэ асуудлыг хариуцсан хуулийн мэргэжилтэн ажиллуулж байна.

Сургалтууд

Олон улсын арга хэмжээ, сургалтууд:

2-р сард ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс Украин улсад зохион байгуулсан “Data4Impact” сургалтанд хамрагдав.

7-р сард мөн тус улсад Дэлхийн банкнаас зохион байгуулсан ИНБ-уудын чадавх бэхжүүлэх сургалтанд Ил тод байдал сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хууль, тогтоомж судалгааны хүрээлэнгийн захирал Д.Тэгшбаяр, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар хамрагдав.

7-р сард Гүрж улсын нийслэл Тбилиси хотноо зохион байгуулагдсан Нээлттэй засаг түншлэлийн бага хуралд ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайдын ажлын албаны дарга Б.Энх-Амгалан нар Монгол улсыг төлөөлөн оролцов.

Үндэсний түвшний сургалт, арга хэмжээ:

3-р сард “Ил тод, хариуцлагатай уул уурхай 2018” сургалтыг 150 гаруй компаниудад зохион байгуулав. Мөн сард төрийн өмчит компаниудад зориулсан сургалтыг Эрдэнэс МГЛ ХХК-ай хамтран зохион байгуулж, 10 гаруй ТӨК-ийн ахлах санхүүгийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэв.

6-р сард БОАЖЯ-ай хамтран “Байгаль орчны мэдээллийн ил тод байдал” олон талт оролцогчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, усны засаглалын асуудлыг хэлэлцэв. Үр дүнд нь 2017 оны тайлагналын хүрээнд шинэ маягт батлаж, 113 компанийн ус ашиглалтын мэдээллийг ил тод болголоо.

7-р сард ХБХН-эй хамтран Ажлын хэсгийн гишүүдэд Эхлэлийн семинарыг зохион байгуулсан.

9-р сард Нээлттэй нийгэм форум, ТАН эвсэл, Компанийн засаглалын үндэсний төвтэй хамтран “Ашиг хүртэгч эздийн ил тод байдал” сэдвийн хүрээнд компани, иргэний нийгмийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.

Ил тод байдал сан ТББ-ай хамтран сэтгүүлчдийн сургалтыг 6, 8-р сард, Олон улсын санхүүгийн корпораци, Инновацийн төвтэй хамтран 40 гаруй оюутан сурагчдад тоо мэдээлэл ашиглах арга зүйн сургалтыг 10-р сард тус тус зохион байгуулж тоо мэдээлэл ашиглалтыг нэмэгдүүлэв.

Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хамтарсан зөвлөгөөнийг 10 дугаар сард, 12 дугаар сард ЕСБХБ-ны санхүүжилтээр “Ашиг хүртэгч эздийн ил тод байдал: Монгол улсын бодлого, хэрэгжилт” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг тус тус зохион байгуулсан байна.

Орон нутгийн түвшний сургалт, арга хэмжээ:

Орон нутгийн гэрээний мониторингийн ажлын хүрээнд Миний монголын газар шороо, Хөвсгөл далайн эзэд, Их баян шарга ТББ-уудтай хамтран Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Төв аймгийн Заамар сумдын дэд зөвлөлийн сургалт, уулзалтыг 6-р сард, Байгаль эхийн аврал сан ТББ-ай хамтран Увс аймгийн ОУИТБС-ын өдөрлөгийг 7-р сард тус тус зохион байгуулав. 4 жишиг сумын мэдээллийн ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалтыг Улаанбаатар хотноо 5-р сард, цахимаар Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн дэд зөвлөлд тус тус сургалт зохион байгуулав. 12-р сард Увс аймгийн төв Улаангом суманд ОУИТБС-ын баруун бүсийн чуулганыг зохион байгуулав. Чуулганд Улаанбаатар хотоос Авилгатай тэмцэх газар, БОАЖЯ, ТЕГ, ТАН эвсэл, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын мэдээллийн ажилтан, АМГТГ, ажлын алба оролцов.

Сурталчилгаа

Хэвлэл мэдээллийн ажлыг энэ жил Мэгүүн мэдиа ХХК-ай гэрээлж гүйцэтгэв. 5-р сард гэрээ байгуулж 6 дугаар сард бүтэн олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр шат

дараатай компани т ажлыг зохион байгуулсан болно. Тухайлбал, 30 мин нэвтрүүлэг бэлтгэж 5 ТВ-ээр цацсан. 12 дугаар бүхий сонины багц ярилцлага, нийтлэл, нийгмийн сүлжээгээр идэвхжүүлэлт, 2 удаагийн анимэйшн, товч ярилцлага, инфографикуудыг бэлтгэн нийтэллээ. Үр дүнд нь нийгмийн сүлжээгээр 140,000 гаруй хүнд мэдээлэл хүрсэн байна. Албаны пэйж хуудас дагагчдын тоо 700-аар нэмэгджээ. Эдгээрээс гадна тодорхой арга хэмжээнүүдийн үеэр хэвлэлийн ярилцлага өгч, өөрийн пэйж хуудаснаа тогтмол мэдээлж ажиллаа.

Танилцуулга, брошур тараах материалуудыг хэвлэн нийтэлж түгээв. 4 жишиг суманд хийгдсэн гол ажлуудыг 2018 оны тайлан байдлаар сонин бэлтгэж тус бүр 2000 ширхэгийг хэвлэж, сумын өрх бүрт түгээж ажиллав.

Хоёр. 2018 оны Ажлын төлөвлөгөөгөөр тавьсан зорилгуудаа хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн⁴

ГУРАВ. ОУИТБС-ЫН ШААРДЛАГА БҮРИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ, ЯВЦ

2017 оны нэгтгэл тайлан ОУ-ын стандартын шаардлагыг хангасан эсэх

Монгол Улс ОУИТБС-ын стандартын шаардлагуудыг хангасан тухай ОУИТБС-ын Удирдах хороо 2018 оны 2 дугаар сард шийдвэрийг гаргасан байна.

Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалт- Үнэлгээ 2016/2017		Шаардлага бүрийг хангасан байдал	
Ангилал	ОУИТБС-ын стандартын шаардлагууд	Дугаар	Хангалттай/гүй
ОУИТБС-ын үйл ажиллагаа, оролцоо, хяналт	Засгийн газрын оролцоо	1,1	Хангалттай
	Компанийн оролцоо	1,2	Хангалттай
	Иргэний нийгмийн оролцоо	1,3	Хангалттай
	Олон талт бүлгийн удирдлага, үйл ажиллагаа	1,4	Хангалтгүй
	Ажлын төлөвлөгөө	1,5	Хангалттай
Тусгай зөвшөөрөл, гэрээнүүд	Эрх зүйн орчин	2,1	Хангалттай
	Тусгай зөвшөөрлийн олголт	2,2	Хангалттай
	Тусгай зөвшөөрлийн бүртгэл	2,3	Хангалттай
	Гэрээ хэлэлцээр, тэдгээрийг ил тод болгох бодлого	2,4	Хангалттай
	Бенефициарь өмчлөгч	2,5	Шаардлагагүй
	Төрийн оролцоо, эзэмшил	2,6	Хангалттай
Олборлолт,	Хайгуулын мэдээлэл	3,1	Хангалттай

⁴ Нэгдүгээр хавсралтаар 2018 оны үйл ажиллагааны биелэлт, үр дүнг харуулсан байна.

хяналт	Олборлолтын мэдээлэл	3,2	Хангалттай
	Экспортын мэдээлэл	3,3	Хангалттай
Орлого төвлөрүүлэх	Иж бүрэн байдал	4,1	Хангалттай
	Мөнгөн бус орлого	4,2	Шаардлагагүй
	Бартерын хэлцэл	4,3	Шаардлагагүй
	Тээвэрлэлтийн орлого	4,4	Хангалттай
	Төрийн өмчит компаниудын шилжүүлэг	4,5	Хангалтгүй
	Орон нутагт шууд төлдөг төлбөр	4,6	Хангалттай
	Задаргааны түвшин	4,7	Хангалттай
	Мэдээллийн цаг хугацаа	4,8	Хангалттай
	Мэдээллийн чанар	4,9	Хангалтгүй
	Орлогын хуваарилалт	Орлогын менежмент, хуваарлалт	5,1
Орон нутгийн шилжүүлэг		5,2	Хангалтгүй
Орлогын зарцуулалт		5,3	Шаардлагагүй
Нийгэм эдийн засгийн хувь нэмэр	Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1a	Хангалтгүй
	Сайн дураар тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1б	Шаардлагагүй
	Төрийн өмчит компаниудын нийгмийн зарцуулалт	6,2	Хангалттай
	Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	6,3	Сайн
Үр дүн, үр нөлөө	Олон нийтийн хэлэлцүүлэг	7,1	Хангалттай
	Мэдээллийн хүртээмж	7,2	Шаардлагагүй
	Зөвлөмжүүдийн биелэлт	7,3	Хангалттай
	Үр дүн, үр нөлөө	7,4	Хангалттай

Дөрөв. 2016 оны нэгтгэл тайлангийн зөвлөмжийн биелэлт ба Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ ⁵

Зөвлөмжүүд	2016 оны ОУИТБС тайлагнал дахь лавлагаа	2017 оны ОУИТБС тайлагналаар хэрэгжүүлсэн эсэх	Тайлбар
		Статус	

⁵ Баталгаажуулалтын үр дүнг бататгах нэмэлт төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.

Төрийн байгууллагуудаас тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг баталгаажуулах журмыг амжилттай хэрэгжүүлэх ажлыг УАГ-тай хамтран зохион байгуулах нь зүйтэй	6.2.1	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	Монголын УАГ-ын 2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөөндөө баталгаажуулах журмыг оруулж өгөх хэрэгтэй
ОУИТБС-ын ач холбогдол болоод ОУИТБС-ын мэдээллийг бэлтгэдэг Засгийн Газрын агентлагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг таниулах ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөс батлах нь зүйтэй.	6.2.2	Хэрэгжүүлсэн	ОУИТБС-ын тайлангийн мэдээлэлтэй холбоотой сургалт, семинарыг хараат бус хянагч-нэгтгэгч зохион байгуулсан.
ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартын тухайлсан шаардлагуудын талаарх сургалтыг ОТАХ болон МОУИТБС-ын Ажлын албаны (эсвэл хөндлөнгийн мэргэжилтнүүдийн) зүгээс Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажил эхлэхээс тодорхой хугацааны өмнө зохион байгуулах, сургалтын гарын авлага танилцуулах гэх мэтээр ТӨААН-үүдийн чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх нь зүйтэй.	6.2.3	Хэрэгжиж байгаа	МОУИТБС-ын 2018 оны тайлангийн ажлын төлөвлөгөөнд багтсан. Хэрэгжиж байгаа.
МОУИТБС-ын цахим тайлангийн системд НӨАТ-ын орлогын урсгалыг дараах 2 байдлаар ялган тайлагнах боломжтой байхаар загварчлах нь зүйтэй: - Татварын албанд төлөгдөх НӨАТ; болон - Гаалийн албанд төлөгдөх НӨАТ	6.2.4	Хэрэгжүүлсэн	Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарт төлсөн НӨАТ-ын мэдээлэл цахим тайлангийн системд тусдаа харагдаж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлсэн
ЗГ-ын түвшинд бизнесийн олон үйл ажиллагаа эрхэлдэг аливаа аж ахуйн нэгжийн олборлох үйлдвэрлэл эсвэл бусад бизнесийн үйл ажиллагаанаас орсон орлогын урсгалуудыг хооронд нь ялгаж, тайлагнах шинэ тогтолцоо бий болгон түүнийг хэрэгжүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй.	6.2.5	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	Төслөөр тайлагнах асуудлуудыг тодорхойлж өгөхдөө энэхүү тогтолцоог бий болгож ажиллахыг МОУИТБС-д зөвлөж байна
ОУИТБС-ын стандартаар шаардсан наад захын шаардлагуудад нийцсэн мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлэх үүднээс тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг АМГТГ-ын зүгээс сайжруулах арга хэмжээг авах нь зүйтэй.	6.2.6	Арга хэмжээ авах шаардлагатай	Хэрэгжүүлээгүй
Үндэсний зөвлөл эсвэл ОТАХ нь БХГ-г ил тод болгох асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тавьж, одоогоор хүчин төгөлдөр байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ОУИТБС-ын стандартын дагуу олон нийтэд ил тод болгох нь зүйтэй.	6.2.7	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	БХГ-нүүдийг ил тод болгоогүй байна

Тав. Монгол Улсад 2018 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд үүссэн бэрхшээл, хариу арга хэмжээ, авсан сургамж

1. Монгол Улсын ОУИТБС-ын 12 удаагийн нэгдсэн тайланг гаргаж, тайлангаас тайланд хамрагдаж байгаа компанийн тоо нэмэгдсэн ч тайлан гаргахгүй байгаа компаний тоо өндөр хэвээр байна. Тооцоогоор 500 орчим компани тайлангаа гаргахгүй байгаа нь 2017 оны 7 дугаар сарын 1- нээс хүчин төгөлдөр болсон “Захиргааны зөрчлийн тухай” хуулиар 10 сая төгрөгийн торгууль хүлээж байна. Гэвч компанийн төлөөлөл торгуулийг хүлээн зөвшөөрөхгүй, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ажлын албаны хооронд үл ойлголцол үүсгэж байна.
2. Засгийн газрын байгууллагуудаас, тухайлбал Гаалийн ерөнхий газар Хянан нэгтгэгчид тодруулга тайлбар гаргаж өгөх ажилд хойрго хандсан хэвээр байна. Энэ асуудлыг цаашид эрхзүйг тодорхой болгох шийдвэрлэх хэрэгтэй байна.

3. Нэгтгэл тайлангаар гарсан мэдээллийн ашиглалт төдийлөн сайн биш байна. Цаашид нэгтгэл тайлангийн ашиглалтыг сайжруулах, зорилтот бүлгүүдэд зориулан амар хялбар ойлгохуйц хэлбэрээр хэвлэн нийтлэх, холбогдох сургалт сурталчилгааны ажлыг улам идэвхжүүлэх хэрэгтэй байна.
4. Монгол Улсын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгдсөн зарим ажил, үйл ажиллагааг олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож буй уул уурхайн салбарын мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна. Ингэснээр мэргэжлийн байгууллагуудын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх боломжтой болно.
5. Засгийн газрын байгууллагуудын оролцоо харьцангуй сайн байгаа ч, холбогдох байгууллагуудын дээд шатны удирдлагын оролцоо хангалтгүй байна. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдийн ирц хангалтгүй, орлож ирэх үзэгдэл оршсоор байна.
6. Компаниуд, тэдний төлөөллийн оролцоо хангалтгүй, идэвхгүй хэвээр байна. Ялангуяа, манлайлал болохуйц томоохон компаниудын захирлууд, хуулийн удирдлагын оролцоо идэвхгүй байна.
7. Аймаг нийслэл, сум дүүргийн түвшинд ОУИТБС түүний шинэ бодлого, нэгтгэл тайлангийн мэдээллийг боловсруулж хүргэх, тэнд байгаа институцийг чадавхжуулах, эрхзүйн болон санхүүгийн орчныг баталгаажуулах, удирдамж чиглэлээр хангаж ажиллах шаардлага хэвээр байсаар байна. Сонгууль болгоны дараа холбогдох ажил хариуцсан албан тушаалтнууд солигдож байгаа нь залгамж байдал алдагдаж, цаг алдахад хүргэж байна. Иймд тогтвортой суурьшилтай ажиллах нөөц бололцоог хангаж ажиллах их чухал байна.

Зургаа. Зарцуулалтын тайлан

Монголын ОУЗСтөслийн болон Улсын төсвийн санхүүжилтын 2018 оны зарцуулалтын тайлан

	Зарцуулалтын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эх үүсвэр
		MNT	MNT	
1	Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаан, зөвлөгөөний зарцуулалт	4 247 820	2 338 105	Дэлхийн банк
2	2017 оны буюу 12 дугаар нэгтгэл тайлан	228 930 000	205 495 000	Улсын төсөв
3	Орон нутгийн гэрээний мониторинг	20 000 000	18 260 200	Дэлхийн банк
4	ОУИТБС-ын орчуулгын ажиллагаа	3 750 000	2 450 000	Дэлхийн банк
5	2016 оны буюу 11 нэгдүгээр тайлангийн хэвлүүлэх, дахин боловсруулах	25 650 000	25 873 382	Дэлхийн банк
6	Олон улсын болон бүс нутгийн арга хэмжээ	10 400 000	11 433 957	Дэлхийн банк
7	ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагаа	10 000 000	6 750 000	Дэлхийн банк
8	ОУИТБС-ын гишүүний татвар	25 500 000	25 499 871	Улсын төсөв
	Ажлын албаны үйл ажиллагаа			
1	Төлөвлөлт, үнэлгээ, сургалт сурталчилгаа	65 000 000	31 877 580	Дэлхийн банк
2	Ажлыг албаны цалингийн зардал	246 760 000	252 937 263	Дэлхийн банк
3	Урсгал зардал	126 400 000	149 652 115	WB Grant

	Нийт	766 637 820	732 567 473	
	Улсын төсөв	254 430 000	230 994 871	
	Дэлхийн банк	512 207 820	501 572 602	

Долоо. Хурал үйл ажиллагаанд оролцсон байдал, туршлага судлах, ирц

7.1 Үндэсний зөвлөл

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдав. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

1. Монгол Улсын “Улаанбаатар аудит корпораци”, Их Британийн “Харт Нойрс” компаниудын консорциумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны буюу 12 дугаар нэгтгэл тайланг дэмжиж, хуралдаан дээр гишүүдээс гаргасан саналыг тусган батлахаар тогтов. Монгол Улсын 2017 оны тайланг оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, Ажлын албанаас хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв. Монгол Улсын 2017 оны нэгтгэл тайлан, 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайлан, 2019 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2018 оны 12 дугаар сарын 31- ний дотор хүргүүлэхийг Ажлын албанд даалгав. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэвлэлийн мэдээллийн хэсэгт даалгав. Гэрээт ажлын үлдэгдэл мөнгийг Монгол Улсын “Улаанбаатар аудит корпораци”, Их Британийн “Харт Нойрс” компаниудын консорциумд төлж барагдуулахыг Ажлын албанд зөвшөөрөв. Энэхүү тайлангаар өгсөн зөвлөмжүүдийн хүрээнд дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд: ОУИТБС-ын 2017 оны тайлангаа гаргаагүй компаниудын нэрсийг хэвлэн нийтлэх, Улсын мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэхийг Ажлын албанд даалгав; Улсын Мэргэжлийн хяналтын газраас тайлан гаргаагүй компаниудтай хариуцлага тооцсон танилцуулгыг Үндэсний зөвлөлд ажлын журмаар танилцуулахыг санал болгов. Олгогдсон тусгай зөвшөөрлүүдийн өргөдлийн огноог Кадастрын санд оруулж ил тод болгохыг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгав. Газрын тосны бүтээгдэхүүний гэрээний ил тод байдлыг бүрэн хангах боломжийг УУХҮЯ нягтлан үзэхийг санал болгов. Аймгийн засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэж, Үндэсний зөвлөлд мэдээлэл өгөхийг УУХҮЯ- д санал болгов. Ашигт малтмалын төрлөөр нь төсөвт оруулж буй, хувь нэмрийг ангилж өгөхийг консорциумд санал болгов. УИХ-ын ЭЗ болон Төсвийн байнгын хороодод 2017 оны нэгтгэл тайланг танилцуулахыг Ажлын албанд даалгав. Тодруулгат хариу өгөөгүй байгууллагуудын нэрийг олон нийтэд нийлэхийг Ажлын албанд даалгав.
2. Монголын ОУИТБС-ын 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2019 оны ажлын төлөвлөгөөтэй танилцаж, гишүүдийн саналыг тусган батлав. Монголын ОУИТБС-ын 2018 үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайланг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов. Ахиц дэвшлийн тайланд оруулах оролцогч тал болох Засгийн газар, компани, иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн ажлын товч танилцуулгыг 12 дугаар сарын 28-наас өмнө Ажлын албанд ирүүлэхийг УУХҮЯ, Монголын УУҮА, ТАН, МБОИЗ-д санал болгов. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажлыг дэмжих ЕСБХБ-ний төслийн явц, үр дүнг танилцуулахыг Ажлын албанд даалгав.
3. Ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох замын зураг-2020 он” төлөвлөгөөний биелэлтийн явц, шинэчилсэн төлөвлөгөөг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов. Ашиг хүртэгч эздийн тодорхойлолт, нэр томъёог хуульд заасны дагуу жигдрүүлж, мөрдүүлэхийг Ажлын албанд даалгав.
4. Засгийн газрын тогтоолын нэмэлт өөрчлөлтийн төслийг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов. Холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанд оруулж, батлуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны уул уурхайн бодлогын газарт

даалгав.Тогтоолын үзэл баримтлалыг ЗГХЭГ- д танилцуулах Ажлын дэд хэсгийг байгуулах, дэд хэсэгт орох төлөөллийн нэрсээ оролцогч талууд 12 дугаар сарын 31-нээс өмнө ирүүлэхээр тогтов.

7.2 Ажлын хэсэг

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон талт Ажлын хэсэг 2018 оны 5, 8, 11 дүгээр саруудад нийт 3 удаа хуралдав.

Ажлын хэсгийн 46 дугаар хуралдаан 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Пума зочид буудал дээр болсон. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

1. ОУИТБС-ын орон нутгийн туршилтын төслийг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган, амжилттай оролцож, дэмжин ажилласан бүх хүмүүс, талуудад гүн талархал илэрхийлэх, Ажлын хэсгийн ахлагчийн гарын үсэгтэй талархалыг хүргүүлэх;
2. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг үндэслэн төслийг өргөжүүлэхийг зарчмын хувьд дэмжихээр тогтов.
3. Хуралдаан дээр гишүүдээс гарсан саналуудыг нэгтгэн 2019 оны дэд зөвлөлийн төсвийн төслийг нийт 288 сая төгрөгөөр батлах нь зүйтэй гэж үзэв.
4. Аймаг, нийслэл, сум дүүргээр зардлын тооцоог илүү нарийвчлалттай хийж, эргэж танилцуулахыг Ажлын албанд даалгасугай.
5. Дэд зөвлөлийн жил бүрийн төсвийн төслийг журмын дагуу батлуулж байх арга хэмжээ авахыг Ажлын албанд даалгасугай.
6. Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай багц хуулийн төслийн тухай Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Ч.Цогтбаатарыг танилцуулгыг сонсч УУХҮЯ-нд талархал илэрхийлэх;
7. Хуулийн төслийн явцын талаар Ажлын хэсэгт мэдээлэл өгч, холбогдох төлөөллүүдийг оруулж, хамтран ажиллахыг хүсэлт болгов.
8. Монголын ОУИТБС-ын 2018 оны баталгаажуулалтын дүнг бататгах ажлын төлөвлөгөөний төслийг батлав.
9. Төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын албанд даалгав.
10. "ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох" сэдвийн дагуу Ажлын хэсэг байгуулж, судалгааг үргэлжүүлэх, Ажлын хэсгийг УУХҮЯ-ны УУБ-ын газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннастаар ахлуулан байгуулах.
11. Оролцогч талууд төлөөллийн нэрсээ 5 дугаар сарын 15-ны Ажлын албанд ирүүлэхээр тогтсон байна.

Ажлын хэсгийн 47 дугаар хуралдаан 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Пума зочид буудалд болсон. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

1. Эхлэлийн тайланг батлах, холбогдох төлбөрийг хийхийг Ажлын албанд зөвшөөрөв;
2. Нэгтгэлийн явцын тайланг 9 дүгээр сарын 30, нэгтгэл тайлангийн төслийг 11 дүгээр сарын 15-ны дотор тус тус Ажлын хэсэгт танилцуулах;
3. Ашигт малтмалын тухай хуулийн 48,10 заалтын биелэлтийг гаргаж, тайлан гаргаагүй компаниудын нэрсийг нийтэд ил тод болгох;
4. Холбогдох тодорхойлолт, маягтыг дахин боловсруулж, компаниудын төлөөлөлд танилцуулж, тэдний саналыг авахыг Ажлын албанд даалгав.
5. Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмж "Хариуцлагатай уул уурхайн санаачилга" ТББ-ын зохицуулагч Д.Сүхбаатар, МУУҮА-ийн гүйцэтгэх захирал Д.Энхболд нарыг томилохоор болов. Дэд ажлын хэсэг Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Ажлын хэсгийн дараагийн хуралдаанд эргэж танилцуулахаар тогтов.

Ажлын хэсгийн 48 дугаар хуралдаан 2018 оны 11 дугаар сарын 19-ний өдөр Пума зочид буудалд болов. Шийдвэрүүдийг сийрүүлэв.

- 1 Тайлангийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Үндэсний зөвлөлийн хуралдаанд сайтар бэлтгэж, танилцуулж, батлуулахыг Улаанбаатар аудит корпорац ХХК, Ажлын албанд даалгав.
- 2 Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс гэрээ ёсоор холбогдох графикт төлбөр 50⁶ хувийг төлөхийг Ажлын албанд зөвшөөрөв.
- 3 Бүрэлдэхүүнд даргаар УУХҮЯ-ы УУБГ-ын дарга Б.Дэлгэржаргал, гишүүдээр мөн яамны Д.Дамба, Оюу толгой ХХК-ийн захирал Т.Мөнхбат, МУУҮА-ийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, ТАН эвслээс Нээлттэй нийгэм формын менежер Д.Эрдэнэчимэг, Хариуцлагатай уул уурхай ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Сүхбаатар, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарыг томилов. Саналаараа орох гишүүд нэрээ яаралтай өгөх нь зүйтэй байна.
- 4 Ажлын хэсгийн гишүүдэд хурал, зөвөлгөөн, үнэлгээний хороо, дэд хэсэгт орж ажилласан байдлыг үнэлгээг гаргаж, урамшуулалын тооцоог цахимаар танилцуулж, холбогдох газарт хүргүүлэхийг Ажлын албанд зөвшөөрөв.
- 5 Үнэлгээний суурь нэгжийг өмнөх жишгийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралд 1 удаа оролцоход 50,000 төгрөг, Ажлын дэд хэсгийн хуралд 1 удаа оролцоход 40,000 төгрөг, Үнэлгээний хороонд ажиллахад 150,000 төгрөг байхыг зүйтэй гэж үзэв.
- 6 Ажлын албаны ажилтнуудад үр дүнгийн урамшуулал 30 хувийг олгох асуудлыг зарчмын хувьд дэмжив.

Гадаад арга хэмжээ

2018 оны 4 дүгээр сарын 8-13-ны өдрүүдэд Украин Улсын ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүд Монгол Улс айлчилж туршлага судлав.

Украин Улсын ОУИТБС-ын ажлын хэсгийн 6 гишүүн, ажлын албаны төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, ОУИТБС-ын хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцаж, Монголын Ажлын хэсгийн гишүүдтэй хамтарсан семинар, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, Төв аймгийн Заамар суманд очиж, сумын дэд зөвлөлийн ажилтай танилцсан байна. Энэ аялалыг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн санхүүжүүлж, хамтран ажилласан байна.

2018 оны 7 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Гүрж Улсын Тбилиси хотноо Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид туршлага судлав.

“Нээлттэй засаг түншлэл” олон улсын Засгийн газар хоорондын байгууллага, ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын урилгаар ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайдын ажлын албаны дарга, Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энх-Амгалан нар Гүрж улсад айлчилж, Нээлттэй засгийн түншлэлийн дээд хэмжээний уулзалтад оролцохын хамт ОУИТБС-ын Төв Ази, Өвөр Кавказын бүсийн хуралд оролцож, ОУИТБС-ын хэрэгжилтийн байдлаа танилцуулж, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох тухай хэлэлцүүлэгт оролцож, Гүрж Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх боломжтой ажлын талаар санал солилцсон байна.

2018 оны 10 дугаар сарын 16-19-ны өдрүүдэд Тажикстаны нийслэл Душанбе хотноо зохиогдсон олон улсын хуралд оролцов.

Тажикстаны нийслэл Душанбе хотноо ОУИТБС-ын олон улсын хурал зохиогдож, түүнд Украин, Кыргызстан, Монгол, Казакстан улсуудын ОУИТБС-ын ажлын хэсэг, албаны төлөөлөл оролцсон байна. Уг хуралд ОУЗСТ-ийн ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон оролцож, Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгааг танилцуулж, сонирхосн асуултад хариулж, туршлага хуваалцахын хамт Тажикстан улсын ОУИТБС-ын хэрэгжилтийн явц,

⁶ Хурлын материалд 60 хувь гээд арифметикийн алдаатай орсныг залруулав.

ахицтай танилцсан байна. Тажикстан Улс нь ОУИТБС-ын 2 дахи тайлангаа гаргаж, баталгаажуулалтдаа бэлтгэж байгаа улс юм. .

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 14- ны 289 дугаар тогтоол

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн даргаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Ажлын хэсгийн ахлагчаар УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргыг томилсон байна.

Найм. Тайланг боловсруулсан: 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр, баталсан огноо: 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Ес. Хавсралтууд:

1. Монголын ОУИТБС-ын 2018 оны төлөвлөгөөний биелэлт
2. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн 2018 нэмэлт арга хэмжээний биелэлт
3. Монголын ОУИТБС-ын 2019 оны төлөвлөгөө
4. Монголын ОУИТБС-ын хүрээнд ашиг хүртэгч эздийг ил тод болгох 2020 он замын зураг төлөвлөгөөний биелэлт
5. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдааны ирц